

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
**2026 оны 5 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг**

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-3
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	4-23

---

<b>1. “Ухаалаг засаг 2” төслийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох</b>	4-23
--	------

---

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны  
5 дугаар сарын 20-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны дарга Ч.Анар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 20 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Соронзонболд;  
Чөлөөтэй: Х.Булгантуяа.

**Нэг. “Ухаалаг засаг 2” төслийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил,  
инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Цэнгүүнжав, мөн газрын Цахим шилжилтийн төсөл, хөтөлбөрийн бүртгэл, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Болормаа, Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч Б.Энхдөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

“Ухаалаг засаг 2” төслийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны мэдээллийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Цэнгүүнжав танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд 12 цаг 50 минутаас 13 цаг 20 минутад хуралдааныг даргалав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан, С.Цэнгүүн, Р.Батболд, Ч.Анар нарын тавьсан асуултад Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Цэнгүүнжав, Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч Б.Энхдөлгөөн нар хариулж, тайлбар хийв.

Дэд хорооны дарга Ч.Анар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Ухаалаг засаг 2” төслийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 13 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн**

**талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Дэд хорооны дарга Ч.Анар бусад Байнгын хороодын хуралдаан давхцаж байгаа тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох асуудлыг хойшлуулав. /13:36/

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 13 минут үргэлжилж, 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 36 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ  
ДАРГА

Ч.АНАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААН ЗОХИОН  
БАЙГУУЛАХ ГАЗРЫН  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## **ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Ч.Анар:** Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Дэд хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын хөгжлийн дэд хорооны 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Их Хурлын гишүүн Чинбаатарын Анар миний бие, Цэндийн Баатархүү, Ренчиндоржийн Батболд, Батбаярын Жаргалан, Саруулсайханы Цэнгүүн гишүүд хүрэлцэн ирснээр хуралдаан нээснийг мэдэгдье.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 2 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт, “Ухаалаг засаг 2” төслийн хэрэгжилтийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох

2-т, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын мэдээллийг сонсох.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүд байна уу. Алга байна. Сайд нь Засгийн газрын хуралдаан явж байгаа учраас хүрэлцэн ирэх боломжгүй байна гэсэн үү. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд томилолттой, Төрийн нарийн бичгийн дарга нь Засгийн газрын хуралдаанд оролцсон байгаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой дэд хорооны хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Мягмарнаран Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга орж ирэх юм байна. Цэнгүүнжав Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга байна уу. Болормаа Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Цахим шилжилтийн төсөл, хөтөлбөрийн бүртгэл, хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн байна. Энхдөлгөөн Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч байна.

Гишүүдэд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас бэлтгэж ирүүлсэн мэдээллийг урьдчилан тараасан байгаа. “Ухаалаг засаг 2” төслийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Дижитал шилжилт, инновацийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цэнгүүнжав танилцуулга, мэдээлэл хийнэ үү. Индрийн микрофоныг өгье.

**Д.Цэнгүүнжав:** Өдрийн мэнд хүргэе гишүүдэд. Тэгээд танилцуулгыг эхэлье.

## “Ухаалаг засаг 2” төслийн үйл ажиллагаа.

“Ухаалаг засаг” төсөл маань хугацааны хувьд 2023 оны 1 сарын 1-ээс 2027 оны 7 сарын 30-ны хугацаанд хэрэгжихээр байгаа. Төсөл хэрэгжүүлэгч байгууллага Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Санхүүжүүлэгч Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци. Төслийн чиглэл Цахим хөгжил, боловсрол. Санхүүжилт 41,7 сая ам.доллар, Төслийн маань зорилго иргэд, аж ахуйн нэгжид үзүүлэх төрийн дижитал үйлчилгээний хэрэглээ, үр ашгийг сайжруулах, дижитал ур чадвар болон дижитал технологи суурьтай ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино гэж байгаа. Төсөл 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.

1 дүгээр хэсэг дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх;

2 дугаар хэсэг Дижитал засгийн шилжилтийг эрт нэвтрүүлэх;

3 Дижитал эдийн засгийн хөгжлийг дэмжих;

4 дүгээрт нь төслийн удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх гэсэн бүрдэл хэсгүүдтэй байна.

Төслийн үр шим хүртэгч байгууллагуудыг энд харуулж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Цахим яамны харьяа Үндэсний дата төв, И-Монгол академи, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв, Ай Ти парк.

## Төслийн цаглавар.

Төсөл маань 2022 оны 6 сарын 6-нд Дэлхийн банкны Удирдах зөвлөлөөр төслийг баталгаажуулсан. Зээлийн хэлэлцээрт гарын үсгийг талууд 2023 оны 1 сарын 10-ны өдөр зурсан. Зээлийн хэлэлцээрийг 2023 оны 1 сарын 20-нд соёрхон баталсан. 2023 оны 4 сарын 6-нд Дэлхийн банк талаас төслийг эхлүүлсэн. 2023 оны 5 сарын 24-нд хэрэгжүүлэгч байгууллагаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болж өөрчлөгдсөн байгаа. 2023 оны 6 сарын 12-нд төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон тоо батлагдсан. 2023 оны 6 сарын 16-нд Төслийн удирдах хороо байгуулагдсан. 2024 оны 1 сарын 1-нд төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа албан ёсоор эхэлсэн байгаа. 2024 оны 6 сарын 5-нд Улсын Их Хурлын 81 дүгээр тогтоол батлагдсан. Энэ гадаад зээлийн тусламжаар хэрэгжиж байгаа төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх, зөвлөх үйлчилгээг санхүүжүүлэхгүй байх, бусад зардлыг хэмнэх тухай тогтоол. 2025 оны 9 сарын 11-нд Дэлхийн банкны төслийн дунд хугацааны үнэлгээ хийгдсэн байгаа. Үүний хүрээнд төслийг хугацаа богино болсон, зарим хэрэгжих боломжгүй төслүүдийг хасаж, дахин бүтэцлэх ийм чиглэл гарч, тэрний дагуу 2026 оны 2 сарын 26-нд төслийн бүтцийг шинэчлэх саналыг хүргүүлсэн байгаа. 2026 оны 2 сарын 5-нд нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжсэн. Төслийн хаалт 2027 оны 7 сарын 30-нд буюу 1 жилийн дараа ер нь хаагдахаар байгаа.

Төслийн удирдах хороо 2023 онд Цахим яамнаас 2, Кибер аюулгүй байдлын зөвлөлөөс 1, Засгийн газрын Хэрэг хэрэг эрхлэх газраас 1, Эдийн засаг, хөгжлийн яамнаас 1, Сангийн яамнаас 1, Байгаль орчин, аялал жуулчлал, залуучуудын

яамнаас 1 байсан 2026 оны байдлаар Цахим яамнаас төлөөлөл 3, И-Монгол академиас 1, Хэрэг эрхлэх газраас 1, Эдийн засаг, хөгжлийн яамнаас 1, Сангийн яамнаас 1 гэсэн бүтэцтэй байна.

2023 онд “Ухаалаг засаг 2” төсөл хэрэгжүүлэх нэгж маань 8 хүний орон тоотой байсан Сангийн яамнаас гарсан чиглэлийн дагуу бүх төслүүд нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж гэдэг зохион байгуулалтад орсон. Үүний хүрээнд 2025 оноос 5 хүний бүрэлдэхүүнтэй буюу нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжээр ажиллаж байна.

Дэд төслийн бэлтгэл ажиллагааны алхмууд ер нь хугацаа нэлээн шаарддаг байгаа. Энийг дунджаар техникийн баримт бичиг боловсруулахад 90-126 хоног зарцуулж байгаа болно. Үүнээс бас дээшээ нэмэгдэх магадлалтай байдаг. Төслийн хэрэгжилттэй холбоотойгоор хоног, хугацааны асуудлыг гаргаж харуулж байна.

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахад 151-182 хоногийг зарцуулж байгаа. Яг энэ манай хэрэгжиж байгаа төслүүд дээр үндэслэж гаргасан тоо байгаа. Энэ төсөл хүчин төгөлдөр болсноос хойш 2,5 жилийн хугацаанд Дэлхийн банкны дунд хугацааны үнэлгээний хүрээнд төсөлд тулгарч буй саад бэрхшээл, шийдвэрлэх үр дүнг сайжруулах зөвлөмжийн хүрээнд төсөл хүчин төгөлдөр болсноос хойших 2 жил хагасын хугацаанд удаа дараа давтагдсан хүний нөөцийн өөрчлөлт нь төслийн хэрэгжилтийн тодорхойгүй байдал, тасалдал, институт нь ой санамжийн алдагдал, хүний нөөцийн чадамжийн хангалтгүй байдлыг үүсгэж, шинээр ажилд орсон ажилтнуудыг дадлагажуулах, туршлагажуулах боломжийг бууруулахад хүргэсэн гэдэг ийм зөвлөмж өгсөн. Тэгэхээр тухайн хугацаанд яасан гэхээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд 3 удаа өөрчлөгдсөн. Төрийн нарийн бичгийн дарга 4 удаа, төслийн захирал 4 удаа, төслийн зохицуулагч 2 удаа, төслийн худалдан авах ажиллагааны мэргэжилтэн 4 удаа өөрчлөгдсөн ийм үзүүлэлтүүд байна. Энэ шалгуур үзүүлэлтүүд. Төслийн хэрэгжилтийн мэдээлэл гэсэн үг. Төсөл анх нийт 69 төсөл арга хэмжээ төлөвлөсөн байснаас дахин бүтэцлэлд хийсний хүрээнд 57 арга хэмжээ болсон. Үүнээс 50 нь гэрээ байгуулах арга хэмжээ, 7 нь чадавхжуулах арга хэмжээ байгаа.

Төслийн хэрэгжилтийн хувь тоон үзүүлэлтээр 72,7 хувьтай байгаа. Ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод Дэлхийн банкнаас зөвшөөрөл авсан 47, одоо 3 ажил хүлээгдэж байсан. Яг энэ танилцуулга бэлдэх хугацаанд өчигдрийн байдлаар 2 төсөл арга хэмжээн дээр санал ирснээр ерөнхийдөө 49 болсон буюу 1 төсөл арга хэмжээн дээр л техникийн даалгавар эцэслэхээр хүлээгдэж байгаа ийм байдалтай байна.

Худалдан авалтыг зохион байгуулсан болон зохион байгуулж байгаа тоо 41, байгуулагдсан гэрээний тоо 29, хэрэгжүүлж дуусгавар болсон гэрээний тоо 20 ширхэг байна.

Нийт төсөл, арга хэмжээний төсвийг задаргаагаар харуулсан. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Үндэсний дата төв гээд яг үр шим хүртэгч байгууллага бүрээр төслийн дүнг харуулсан байна. Нийт дүн 41,1 сая доллароор одоогийн байдлаар яг төсөвт гэрээ байгуулсан дүнгээр төсөвлөөд явж байхдаа ийм байна. Хэрэгжилт 9 буюу 9,5 сая доллар, худалдан авалтад 11,4 сая доллар, бэлтгэл дээр 14 сая доллар, арга хэмжээний хэрэгжилт дээр 507 мянга, эхлээгүй 250 мянга, дууссан нь 1 сая 680 мянга.

Үр шим хүртэгч байгууллагаар төслийг харуулах юм бол Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаман дээр одоо яг энэ жил хэрэгжээд явах 5 төсөл, арга хэмжээ байна. Хөдөө, орон нутгийн харилцаа холбооны дэд бүтцийг сайжруулах, чадавх бэхжүүлэх, үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийн суурь системийг шинэчлэх, чадавх бэхжүүлэх, чадавх хөгжүүлэх гээд ингээд 5 ажил явахаар байгаа.

Үндэсний дата төв дээр 6 ажил байна. Энэ дээр интернэтийн харилцаа холболтын төхөөрөмжийг шинэчлэх, төрийн байгууллагуудын цахим шуудангийн системийн программ хангамж нийлүүлэх хэрэгжиж дууссан. Үүлэн тооцооллын үйлчилгээг ашиглах судалгааг хийх хэрэгжиж дууссан. Үндэсний дата төв болон нөөц төвийн хүчин чадлыг сайжруулах хэрэгжиж буй, Үндэсний дата төвийн нөөц төвийн “б” өрөөг тоноглох худалдан авалтын багц үйл ажиллагаа. Энэ бол одоо зарлагдахаар хүлээгдэж байна. Хиймэл оюун ухааны суурь дэд бүтцийг бий болгох, үүсгэх, хэрэгжүүлэх худалдан авалтын багц.

И-Монгол академи дээр Хур системийн техникийн бие даасан зөвлөх, төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем хурыг тархсан бүтцэд шилжүүлэх, төрийн дижитал үйлчилгээг нэмэгдүүлэх, Үндэсний хөгжлийн индексийн судалгаа, Төрийн их өгөгдлийн сан үүсгэх, хэрэгжүүлэх, худалдан авалтын багц үйл ажиллагаа.

Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв, Кибер аюулгүй байдлын зөвлөл дээр Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвд тавилга нийлүүлэх, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн тоног төхөөрөмжийг нийлүүлэх, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв техник болон программ хангамж нийлүүлэх худалдан авалтын багц үйл ажиллагаа, Үндэсний хэмжээний кибер халдлагад хариу үзүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх багц.

Мэдээлэл, технологийн үндэсний парк дээр суурилад цахим ажлын байрыг нэмэгдүүлэх буюу дижитал эдийн засгийг чадавхжуулах, бэхжүүлэх гэсэн ийм 1 ажил явж байгаа. Энэ ажил маань зарлагдчихсан. Энэ 5 сарын 26-нд нээгдэхээр байгаа. Энэ төслийн хүрээнд нийт 1500 хүнийг сургахаар байгаа. Эндээс мянган хүнийг ажлын байртай болгоно. Ажлын байртай болгохдоо 6 сарын хугацаанд гадаадын цахим хуудас дээр байж байгаа бэлэн цахим ажлуудыг хийгээд, 6 сарын хугацаанд 480 хүртэлх долларыг дансандаа орлого болгож хүлээж авснаар шалгуур үзүүлэлтийг хангахаар хүлээж авахаар тийм тусгасан байгаа.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр Засгийн газрын цахим хурлын системийг шинэчлэх, лиценз худалдан авах, Засгийн газрын архивын тоног төхөөрөмж шинэчлэх, Төрийн албан хаагчдын сургалтын нэгдсэн цахим платформ [surgalt.gov.mn](http://surgalt.gov.mn)-ийг өргөтгөн хөгжүүлэх, сайжруулалт хийх, Засгийн газрын архивын цахим систем хөгжүүлж нэвтрүүлэх, дагалдах тоног төхөөрөмж, Засгийн газрын шийдвэрийн цахим систем хөгжүүлж нэвтрүүлэх, дагалдах тоног төхөөрөмжийн хамт гэсэн энэ 5 төсөл байгаа.

Дахиад нэмэлтээр Засгийн газрын цахим болон танхимын хуралдааны үйл ажиллагаанд дижитал шинэчлэлт хийх шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэх, Засгийн газрын үйл ажиллагаанд ашиглах хиймэл оюуны модель болон сервис худалдан авах, чадавх бэхжүүлэх.

Эдийн засаг, хөгжлийн яаман дээр цахим зөвшөөрлийн системийн функциональ загварчлалыг боловсруулахад шаардлагатай засаг захиргааны үе

шат бүрд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд инженерчлэл хийх бие даасан зөвлөх, зөвшөөрлийн нэгдсэн сангийн системийн загварыг шинэчлэн боловсруулах хүрээнд Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх, үүргийн дагуу тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд процессын шинжилгээ хийх бие даасан зөвлөх, цахим зөвшөөрлийн системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бие даасан зөвлөх, цахим зөвшөөрлийн системийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх бие даасан зөвлөх гэсэн ийм ажлууд.

Дараагийн нэмэлтээр бол Зөвшөөрлийн нэгдсэн сангийн системийн загварыг шинэчлэн боловсруулах хүрээнд Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх, үүргийн дагуу тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд процессын шинжилгээ хийхэд хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, цахим зөвшөөрлийн системийн тоног төхөөрөмж нийлүүлэх, чадавх бэхжүүлэх.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар дээр Монгол Улсын аялал жуулчлалын порталыг хөгжүүлэх, байгаль орчны мэдээллийн сангийн системийг шинэчлэн хөгжүүлэх, дагалдах тоног төхөөрөмжийн хамт улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлыг сайжруулах, дэд бүтцийг бий болгох, улсын бүртгэл дээр чадавх бэхжүүлэх.

Авлигатай тэмцэх газар дээр хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон ХОМ-ийн бүрдүүлэлтийн системийг хөгжүүлэх, дагалдах тоног төхөөрөмжийн хамт гэсэн ийм төсөл арга хэмжээнүүд.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн худалдан авах ажиллагааны газар дээр хуулийн шинэчилсэн найруулгын дагуу гомдол шийдвэрлэх механизмд дүн шинжилгээ хийх, худалдан авах ажиллагааны улсын байцаагчид дэмжлэг үзүүлэх бие даасан зөвлөх, Цахим худалдан авах ажиллагааны системийн техникийн бие даасан зөвлөх, худалдан авах ажиллагааны сургалттай холбоотой журам, зааварчилгаа, баримт бичгийг хянах, сайжруулах, шинэчлэх бие даасан зөвлөх, хуулийн дагуу шинэчилсэн найруулгад нийцүүлэн журам, заавар боловсруулах, талуудын мэдлэг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх бие даасан зөвлөх, төрийн цахим худалдан авах ажиллагааны системийн шинэчлэл хиймэл оюун ухааны модуль хөгжүүлэлт, чадавх бэхжүүлэлт гэсэн төсөл арга хэмжээнүүд байна.

Хүснэгтээр нийтдээ дууссан буюу хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний жагсаалтыг харуулж байна. Танилцуулга дууссан.

**Ч.Анар:** Цэнгүүнжав даргын мэдээлэлтэй танилцлаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Энэ танай өгсөн танилцуулгууд хүн уншихын аргагүй. Албаар ингэж өгөөд байгаа юм уу. Ерөөсөө уншигдахгүй. Хэвлэсэн нь ч уншигдахгүй. Дэлгэц дээр гарч байгаа нь ч уншигдахгүй. Ямар зорилготой ингэж материал өгөөд байна. Төсөл, хөтөлбөрийн мэдээллүүдээ дахиж танилцуулъя. Энэ асуудлаа шийдээд.

Жаргалан гишүүн асуулт асууя.

**Б.Жаргалан:** Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаман дээр “Ухаалаг засаг 2” гээд төсөл 2023 оноос хойш хэрэгжээд эхэлж байгаа юм байна.

Нийт 42 сая ам.долларын нэлээн томоохон үнийн дүнтэй төсөл байна. Ялангуяа энэ салбарын хувьд. Тийм ээ. Тэгээд та бүхэн яг төслийн удирдлагын нэгж энэ төслийн хэрэгжилт ер нь ямар байдалтай байна гэж үнэлж байна. Өнгөрсөн хугацаанд Цахим хөгжлийн сайд 3 удаа солигдсон, Төрийн нарийн нь 4 удаа өөрчлөгдсөн. Төслийн захирал 4 удаа өөрчлөгдсөн гэсэн мэдээнүүд байна л даа. Тэгэхээр ер нь өнгөрсөн хугацаанд энэ төслийн үйл ажиллагаа 2023 оноосоо хойш, анх байгуулагдсан цагаасаа хойш ер нь хэрэгжилт хэр үр дүнтэй байна. Анхныхаа зорилтуудад нь хүрч чадаж байна уу. Ирэх жил дуусах ёстой юм байна шүү дээ. Тэгээд нийт төслийн зорилтууд болон энэ санхүүжилтийн хувь хэмжээнээс яг хэдэн хувь нь гүйцэд хэрэгжчихсэн байгаа вэ. Санхүүжилтийн хувьд ч гэсэндээ яг хэдэн хувийнхаа гүйлгээнүүдийг хийсэн байгаа вэ. Тэгээд анх тавьсан зорилтуудынхаа хүрээнд ямар ямар ажил хангалттай гэж дүгнэгдэхээр байна. Ямар ямар ажил нь хангалтгүй байна гэдэг дээрээ яг үнэн бодитой дүгнэлтүүдийг хэлээд өгнө үү гэж хүсэж байна.

2 дугаарт энэ төслийн хүрээнд ийм тодорхой зорилтуудыг бас дэвшүүлсэн байна. Төрийн үйлчилгээг цахимжуулах гэх мэтийн тийм маш ерөнхий зорилтууд яваад байна л даа. Тэгээд энэ яг энэ хүрээнд яг бодитой ямар ажлууд хийгдсэн байна. Миний тусгайлан сонирхож байгаа хэсэг энэ цахим худалдан авах ажиллагааны системийн сайжруулалт гэнэ л дээ. Төрийн худалдан авах ажиллагааны газарт энэ ямар бодитой үр дүнд хүрсэн бэ. Төрийн их өгөгдлийн сан үүсгэж хэрэгжүүлэх гэж байна. Энэ яг хаана явж байгаа вэ. Хэрэгжилт нь хэдэн хувьтай яваа юм. Тэгээд ямар төрийн албан хаагч нар энд хандаад, тодорхой шийдвэр гаргалтад ямар хувь нэмэр оруулж нөлөөлж байгаа юм бэ гэдэг зарим нэг асуултууд байна.

Тэгээд ер нь цаашлаад та бүхэн энэ цахим хөгжлийн салбарт энэ олон улсын байгууллагуудаас ийм төрлийн төсөл хэрэгжүүлэх нь ер нь цаашид үр дүнтэй байх уу, үгүй юу гэдэг дээр ямар бодит дүгнэлт хийх вэ. Ийм төсөл хэрэгжүүлснээр магадгүй хувийн хэвшлийн оролцоог бас хумьсан зүйл байна уу. Эсвэл нөгөө төрийн бусад байгууллагуудын үйл ажиллагаатай давхардсан зүйлүүд гарч байна уу гэдгээ яг дотор нь ажиллаж байгаа хүмүүсийн хувьд бодитоор бас дүгнээд, цаашид ер нь бид нар ийм зүйлүүд, ийм төслүүд хэрэгжүүлэх нь зөв юм уу, буруу юм уу гэдэг дээр бодитой дүгнэлтүүдийг хэлээд өгөөч.

**Ч.Анар:** Индрийн микрофон өгье.

**Д.Цэнгүүнжав:** Асуултад хариулъя. Төсөл хөтөлбөр, арга хэмжээний хувьд сая хэлсэн. Дэлгэц дээр байгаа, тэгэхдээ харагдахгүй байгаа юм байна. 2025 оны 6 сарын 18-ны байдлаар ажлын даалгавар эцэслүүлсэн буюу яг зарлаад хэрэгжих боломжтой 34 байсан бол нийт арга хэмжээ 69 байсан. Тэрнээс яг эцэслэсэн 34 байсан бол яг жилийн дараа 2024 оны 4 сарын 30-ны байдлаар төсөл арга хэмжээг хэрэгжих боломжгүй, хугацаа бага байгаа учраас зарим арга хэмжээг хассан байгаа. 69 арга хэмжээ хөтөлбөрийг 57 болгож бууруулсан буюу яг энэ үлдсэн хугацаанд амжихаар дахиж бүтэцлэж эрэмбэлсэн. Тэрний дагуу яг одоогийн байдлаар 49 буюу 50 арга хэмжээнээс 1 л арга хэмжээ дутуу буюу бусад нь бүгд бэлэн зарлагдаад, худалдан авах ажиллагаанд явж байгаа буюу төслийн хугацаанаас өмнө амжуулахаар Дэлхийн банкны багтай хамтраад ажиллаж байгаа.

2 дахь асуудал энэ хороогоор хэлэлцүүлэх асуудлын 2 дахь дээр нийт цахим салбарт хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн мэдээлэл байгаа. Тэр дээр харах юм бол яг энэ харагдана. Яг энэ цахим яамтай холбоотой, салбартай холбоотой төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх юман дээр цахим яаман дээр жишээлбэл хоёрхон гадаадын

зээл тусламжаар л энэ томоохон цахим шилжилтийн арга хэмжээнүүд хийгдэж байгаа. Өмнө нь 2021 онд “Ухаалаг засаг 1”-ээр нэлээд асуудлыг шийдэж, одоогийн ХУР системийн дэд бүтцүүд, дата төвийн нөөц төв ч гэдэг юм уу эд нар хэрэгжсэн байдаг бол одоо ингээд дахиад 4, 5 жилийн дараа буюу яг дараагийн хөрөнгө оруулалт шинэчлэлт бол энэ төслийн хүрээнд л хийгдэж чадаж байгаа.

Яг саяын таны хэлсэн төслүүд бүгд яг худалдан авах ажиллагааны шатан дээр явж байгаа. Жишээлбэл худалдан авах ажиллагааны системийн шинэчлэлт бол яг сүүлийн шатан дээр буюу Дэлхийн банк руу үнэлгээ, арифметик алдаа энэ тэрийгээ тооцоод шалгаад Дэлхийн банк руу явуулаад зөвшөөрөл авах юм бол тэндээс мэдэгдэл ирэхээр байгаа. Гэрээ байгуулах мэдэгдэл. Ингээд гэрээ байгуулснаар ажил эхлэхээр байгаа. Тэр их өгөгдлийн болоод дата төвийн 3 багц арга хэмжээ байгаа. Бас адилхан худалдан авах ажиллагааны шатан дээр зарлахад явж байгаа гэсэн үг.

Гүйцэд хэрэгжсэн дээр Улсын бүртгэлийн тэр дэд бүтэц, аюулгүй байдлыг сайжруулах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах гэдэг төсөл бол бүрэн хэрэгжиж дууссан байгаа. Авлигатай тэмцэх газрынх бол ер нь хэрэгжээд дуусна. Ер нь давуутай нөгөө баталгааны ч юм уу тэр хэсгүүд нь үлдчихсэн явж байгаа. Авлигатай тэмцэх газрын ХОМ-ийг гаргадаг системийг бол бүрэн шинэчилсэн байгаа.

Дата төвийн төслүүд хэрэгжээд дууссан. Тоног төхөөрөмжийг нийлүүлэх төслүүд бол хэрэгжээд явсан байгаа. Тэгээд Монголын интернэтийн харилцаа холболтыг шинэчлэх төсөл бас хэрэгжиж дууссан байгаа.

Энэ ингэсэн нөгөө 11 сард хийгдсэн гэсэн үг. Дахин бүтэцлэл. Тэгэнгүүт 2025 оны 11 сар гэдэг маань өөрөө яг 1 жил хагасын ч юм уу зай үлдчихсэн. Тэгээд яг саяын хэлснээр 57 арга хэмжээнээс ажлын даалгавар эцэслээгүй маш олон яг саяын таны хэлдэг худалдан авах тэр дата төв, И-Монголын буюу 10 том төслүүд, тэгээд тэрний чинь техникийн даалгаврыг нь эцэслэх гэж маш их хугацаа шаарддаг. Өмнөх слайд дээр байгаа. Тэгэхээр дунджаар энэ хугацааг нь би эндээс харах юм бол бараг 2-3 сар болдог. 1 дүгээрт нь техникийн даалгавар бэлтгэх, 2 дугаарт нь худалдан авах ажиллагааны процесс гээд бараг доор хаяж 6 сарын хагас жилийн асуудал гардаг учраас яг тэрнээс хойш яваад одоо яг эцэслэгдээд зарлахад бэлэн болоод зарим нь зарлагдаад явж байна гэсэн үг.

**Ч.Анар:** Цахим яам Энхдөлгөөн тодруулъя. Индрийн Микрофон.

**Б.Энхдөлгөөн:** Энэ дээр нэмэлт тайлбар өгье. Дахин бүтэцлэх шаардлага болохоор ...

**Ч.Анар:** Нэр, албан тушаалаа хэлээрэй.

**Б.Энхдөлгөөн:** Б.Энхдөлгөөн “Ухаалаг Засаг 2” төслийн координатор. Одоогоор Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн координатаар ажиллаж байна. Энэ дээр сая дахин бүтэцлэх тухай ярилаа. 2024 оны 6 сарын 5-ны Монгол Улсын Их Хурлын 81 дүгээр тогтоолын хүрээнд Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанууд дээр зөвлөх үйлчилгээ болон өдөр тутмын зардлыг санхүүжүүлэхгүй гэдэг тогтоол гарсан. Энэ тогтоолын хүрээнд манай төслийн хүрээнд хэрэгжүүлэх байсан түрүүн хэлсэн 69 ажлын ихэнх нь зөвлөх үйлчилгээний ажлууд байсан. Санхүүжүүлэх боломжгүй учраас зөвлөх үйлчилгээний ажлуудыг бол бид нар

зайлшгүй цуцлах шаардлагад хүрсэн. Энэ хүрээндээ зөвлөх үйлчилгээний ажлуудаа хасаад, оронд нь тоног төхөөрөмжийн ажлууд оруулаад, дахин бүтэцлэсэн. Тэгэхээр ийм процесстой явж байгаа.

Тэгэхээр нийт төлөвлөсөн ажлуудаас зарим нь хэрэгжээгүй, зарим нь .../минут дуусав/

**Ч.Анар:** Индрийн микрофон 1 минут нэмж өгье.

**Б.Энхдөлгөөн:** Тэгэхээр дунд хугацааны үнэлгээний шатаар бид хэрэгжих боломжгүй төсөл хөтөлбөрүүдээ Сангийн яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон Дэлхийн банкны төлөөллүүдийг авч уулзаад, тэр ажлуудаа хасаад, цуцлаад, Удирдах хороогоороо шинэ тоног төхөөрөмжийн дэд төслүүдийн ажлуудыг оруулж ингэж төлөвлөөд ажиллаж байгаа гэсэн үг.

**Ч.Анар:** Жаргалан гишүүн тодруулга.

**Б.Жаргалан:** Энэ “Ухаалаг засаг 2” төслийн нийт хөрөнгө оруулалтын хэдэн хувь нь яг тоног төхөөрөмж байна. Энэ тоног төхөөрөмжүүд нь ер нь хаанаас импортлогдож байгаа вэ. Тэгээд хэдэн хувь нь бусад төрлийн үйлчилгээ гэдэг юм уу, тиймэрхүү зардлууд байна. Тэгээд нийт төслийн хөрөнгө оруулалтын хэдэн хувь нь дотооддоо шингэж байна вэ гэдэг асуулт.

**Ч.Анар:** Индрийн микрофон. 3 минут. Цэнгүүнжав дарга.

**Д.Цэнгүүнжав:** Бүрэлдэхүүн хэсгийн дижитал засгийн шилжилтийг нэвтрүүлэх буюу 34,8 сая долларын арга хэмжээ бол яг энэ тоног төхөөрөмж, системийн ажлууд байгаа. Эндээс систем хөгжүүлэх ажлууд бол юу гэдэг юм дотоодын компани авсан бол дотооддоо үлдэнэ. Тоног төхөөрөмж ер нь тэр чигээрээ гаднаас л авагдаж байгаа гэсэн үг. Тэрийг нь гаргаад өгье.

**Ч.Анар:** Ялгаад багцааг нь тоолоод гаргаад өгөөрэй.

**Д.Цэнгүүнжав:** Яг энүүгээр ялгасан мэдээлэл байхгүй байна. Тэгэхдээ яг систем, тоног төхөөрөмжөөр нь ялгаад мэдээллийг нь өгье.

**Ч.Анар:** Цэнгүүн гишүүн асуулт асууя.

**С.Цэнгүүн:** Өдрийн мэнд хүргэе. Дөнгөж сая нөгөө худалдан авалттай холбоотой материалууд нь дөнгөж сая орж ирж байна. Тэгээд энэ нөгөө ухаалаг төсөл маань болохоор ер нь иргэдэд төрийн үйлчилгээг амар хялбар, орон зай, цаг хугацаа үл хамаарч авах боломжийг олгож байгаа ийм төсөл байгаа юм. Тэгээд 2023 оноос 2027 он хүртэл 29,5 сая доллароор Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа ийм төсөл юм байна. Тэгээд энэ төслийн маань ерөнхийдөө хамгийн гол 5 үр дүн, өнөөдрийг хүртэл хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдээс 5 гол үр дүн нь юу байгаа юм бол. Тэгээд тэр 5 үр дүнгээ хэмжихдээ болохоороо сургалт хийсэн, зөвлөгөө авсан, судалгаа гаргасан гэхээс илүү яг цаг хугацаа, зардал, шат дамжлага, авлигын эрсдэл буурсан гэх мэт хэмжүүрүүдээр авч үзэж байна уу. Та бүхэн маань яг яаж тэр үр дүнгүүдээ хэмжиж гаргаж байгаа вэ. Тэрийг нэгд асууя.

2-т болохоор худалдан авах ажиллагаа дээр нь бас байгаа анхаарал татсан тоонууд бас харагдаж байна. Жишээ нь 405 сая төгрөгөөр зар сурталчилгаа таниулгын ажлыг тавьж өгсөн байгаа юм. Тэгэхээр энэ 405 сая төгрөгөөр зар

сурталчилгаа хийсэн нь яг ямар зар сурталчилгаа хийсэн юм. Тэр нь яг үр нөлөө бодитой байгаа юм уу. Энэ нь яг КРІ үнэлгээгээр үнэлээд тухайн гүйцэтгэгч нар нь яг ямар тайлан бас буцааж гаргаж өгсөн байгаа юм бол гээд. Яагаад гэхээр маш том төслүүдийг дагалдаад зар сурталчилгааны төлбөр гээд дагалдуулаад гарчихдаг. Тэгээд тэр нь болохоор яг бодитоороо хийгдсэн эсэх нь ч мэдэгддэггүй нэг ийм газартай гэрээ байгуулаад орхичихсон байгаад байдаг. Тэгэхээр энийгээ бас та бүхэн дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө үү.

**Ч.Анар:** Индрийн микрофон Цэнгүүнжав дарга.

**Д.Цэнгүүнжав:** Саяын гаргасан яг үр дүн дээр бол бид нар яг одоогоор тооцоолол юм нарийн яг таны хэлсэн шиг нарийвчилж гаргаагүй байна. Энийг дахиж гаргаад танилцуулъя. Тэгэхдээ ерөнхийгөөр 1 дүгээрт нь дижитал ажлын байрыг нэмэгдүүлэх, 1500 хүнийг бас сургах гээд. Ерөнхийдөө бол сая хэлснээр ихэнх ажлууд маань яг худалдан авах дээр энэ тоон дээр байгаа. 30 хэдэн ажил явж байгаа. Дууссан 29 арга хэмжээний ихэнх нь өмнө нь юу гэдэг юм нөгөө хасахаас өмнө байсан зөвлөх үйлчилгээний ажлууд байгаа. Жишээлбэл 75 үйлчилгээг цахимжуулах гэдэг дэлхийн жишгийн дагуу юу гэдэг юм цахимжуулах гэдэг ажил бол дөнгөж гэрээ нь хийгдэж байгаа гэх мэтчилнээр ихэнх ажил бол яг худалдан авах хэрэгжилтийн шатанд явж байгаа байгаа буюу төслийн ашиглалт, зарцуулалт маань өөрөө 3,8 хувьтай байгаа. Яг санхүүжилт, гарсан санхүүжилтийн дүн гэсэн үг. Тэгэхээр бүгд ихэнх ажил бол хэрэгжилт дээр явж байгаа. Яг бүрэн дууссан гэвэл тэр АТГ-ын систем ХОМ. Жишээлбэл энийг ХОМ бөглөдөг хүмүүс хялбар болсон гэдэг үр дүнг нь бол хэлэх байх. Би өөрөө бөглөдөг. Тэр дээр жишээлбэл маш их мэдээлэл бөглөдөг байсан бол өмнөх мэдээллийгээ шууд аваад, өмнө нь байгаа гэдэг байдлаар ч юм уу ингээд явах боломжтой болсон байгаа. Жишээ нь тэр систем бол маш үр дүнтэй болсон.

Улсын бүртгэлийн газрынх бол яг иргэдийн болоод үндсэн суурь мэдээллийн сан гэдэг утгаараа хадгалалт, аюулгүй байдлыг нь сайжруулах дэд бүтцийн төсөл хэрэгжсэн. Энэ бол үр дүнтэй төсөл гэж үзэж байгаа.

Дата төв ерөөсөө төрийн цахим үйлчилгээний Монгол Улсад явж байгаа төрийн цахим үйлчилгээний 90 гаруй хувь нь дата төвтэй хамааралтай байдаг. Дата төвийн тоног төхөөрөмжийн 60 гаруй хувь нь бол ашиглалтын хугацаа дууссан тийм тоног төхөөрөмжүүд ажиллаж байдаг. Тэрийг шинэчилж өргөтгөл хийсэн энэ ажил бол яг тодорхой үр дүнтэй ийм ажлууд байгаад байгаа. Дууссан ажлууд.

**Р.Батболд:** Цэнгүүн гишүүн тодруулж асууя.

**С.Цэнгүүн:** Яах вэ яг хийсэн ажлуудынх нь үр дүнгээ та бүхэн маань бас яг тооцож чадахгүй байгаа юм болов уу гэж харагдаад байна л даа. Тэгээд энэ ХАСХОМ нь болохоор 2 тэрбум төгрөгөөр хэрэгжсэн юм байна. Тэгээд энэ системийг суурилуулахдаа ерөнхийдөө үндсэн датагаа та нар хаана хадгалж байгаа юм бол. Энэ клауд дээр байршиж байгаа юм болов уу. Эсвэл төвийн төрийн үндсэн дата сан дээр хадгалагдаж байгаа юу.

**Р.Батболд:** Индрийн микрофон..

**Д.Цэнгүүнжав:** Гишүүний өмнөх асуултын нөгөө 400 сая гэсэн. Тэр бол нөгөө цуцлагдсан ажлууд байсан буюу хэрэгжээгүй.

2 дахь тэр АТГ-ын систем бол ерөөсөө Монголын буюу Төрийн байгууллагуудын дата ер нь бүгд Төрийн Үндэсний дата төв дээр хадгалагддаг. Клауд дээр ерөөсөө гадагшаа буюу ер нь дата төв дээр төрийн байгууллагуудын өгөгдөл мэдээлэл Монгол улсад байршина гэдэг утгаараа бүгд төрийн байгууллага дээр байршдаг. Саяхныг хүртэл юу гэдэг юм бүр гаднын нөгөө оффис 365 гэдэг юм уу, гадаадын мэйлийг хүртэл ашиглахгүй байна гэдэг зарчимтай явж ирсэн буюу ер нь бүх өгөгдөл мэдээлэл Үндэсний Дата төв дээр хадгалагддаг.

**Р.Батболд:** Цэнгүүн гишүүн тодруулъя.

**С.Цэнгүүн:** Тэгэхээр миний бодлоор энэ танилцуулга дээр болохоор хэрэгжүүлэх гээд өмнө нь төлөвлөгөөндөө оруулчихсан байсан. Тэгээд одоо хэрэгжүүлэхээ больчихсон төслүүд нь хамт холилдоод ороод ирчихсэн байгаад байгаа юм байна. Тийм үү. Тэгэхээр одоо тэгвэл яг та нарын үндсэн яг төлөвлөгөө чинь юу байгаад байгаа юм. Яг хийгдэх ажлууд төлөвлөөд явчихсан байгаа. Энийгээ яг цэвэрлээд харуулахгүй бол энэ чинь аягүй тийм төөрөгдүүлсэн мэдээллүүд маш их байгаад байна л даа. Тэгэхээр энэ төсөл маань анх төлөвлөхдөө ийм байсан юм байна. Одоогийн 3 жилийн дараагаар ийм шатад энэ ажлууд хийгдэхээр байгаа юм байна. Одоо тэр хугацаанд 3 жилийн хугацаанд эд нар нь ийм үр дүнгээр гаргачихсан байна гээд ойлгомжтойгоор мэдээллээ боловсруулаад өгөхгүй бол ердөөсөө энэ дундаас мэдээллүүдийг нь нягталж харах гэхээр бид нар дээр ирчихсэн байгаа л мэдээллийг асууж байгаа шүү дээ. Тэгж байхад болохоороо одоо наад ажил чинь байхгүй болчихсон юм гээд ингээд суугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр та хэдээс ирсэн мэдээллийг нь л бид бүхэн асууж байгаа. Тийм болохоор энийгээ ахиад нэг сайн сайжруулаад, яг тэгвэл бодитоор хэрэгжиж байгаа нь .../минут дуусав/

**Р.Батболд:** Индрийн микрофон өгье.

**Д.Цэнгүүнжав:** Ер нь бол яг дууссан болон хэрэгжиж байгаа гэдгээр уг нь ангилаад гаргасан. Тэгэхээр дахиж нягтлаад, дэд хороо бол албан бичгээр мэдээлэл авсан. Үүний дагуу дахиж хүргүүлбэ. Яг одоо хэрэгжиж байгаагаар.. Ер нь ойлгоход өмнө нь хэрэгжсэн ихэнх төсөл бол дандаа зөвлөхийн болоод тийм үндсэн төслүүд ерөөсөө яваагүй байсан. Одоо бол бүгд худалдан авах ажиллагааны шатад буюу хугацаандаа дуусгахаар ирэх 2027 оны 7 сарын 30-нд хаагдана. Тийм учраас бид Дэлхийн банкт хамтраад яг энэ зарцуулалт болоод төслийн арга хэмжээг маш шахааж ажилласнаар өнөөдрийн байдлаар 50 арга хэмжээнээс 49 нь буюу бүгд худалдан авах ажиллагаанд, 20-оод орчим нь дууссан. 20 гаруй үлдсэн бүх төслүүд бол худалдан авах ажиллагааны шатад явж байгаа гэсэн үг.

**Р.Батболд:** Хариулт хэлэх гэж байна уу. Индрийн микрофоныг өгчихье.

**Б.Энхдөлгөөн:** Сайн байцгаана уу. Дахиад төслийн зохицуулагч Б.Энхдөлгөөн байна. Манай “Ухаалаг засаг 2” төсөл хөтөлбөр бол зээлийн хэлэлцээр дээр тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Уг үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхдээ бид нар төслийн хөгжлийн зорилгын объект буюу индикаторуудыг бид нарт зааж өгсөн байдаг. Зээлийн хэлэлцээрийн дагуу. Энэ дээр хамгийн чухал индикатор нийт дижитал скилл буюу дижитал ур чадварыг хөгжүүлсэн, төслийн хүрээнд хөгжүүлсэн тийм хувь байдаг. Энэ нь болохоор төслийн хүрээнд хэрэгжүүлснээрээ бид дижитал скилл, үр шим бүтээгч байгууллагуудынхаа дижитал ур чадварыг 30 хувиар нэмэгдүүлнэ гээд тооцсон байдаг.

Өнөөдрийн байдлаар буюу 2025 оны сүүлээр 6 хувиар нэмэгдүүлсэн байдаг. Үүнээс 30 хувь нь эмэгтэй хүн байх ёстой. Эмэгтэйчүүд байх ёстой гэдгээс 8,35 хувь нь эмэгтэйчүүд байна. Үүний дараа бид дижитал шилжилтийн таатай орчныг .../минут дуусав/

**Р.Батболд:** Гүйцээгээд хариулчихъя.

**Б.Энхдөлгөөн:** Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх буюу бүрэлдэхүүн хэсгийн зорилго, зорилт дээр бид дижитал шилжилтэд зориулсан бодлогын шинэчлэл болон регулэйшнүүдийг баталсан байх ёстой гэсэн тоо байгаа. Үүнээс бид нарын нийт зорилго 5 байсан. Нийт 5 бодлогын бичиг баримтыг баталсан. Цахим хөгжлийн яам бол хэрэгжүүлсэн байх ёстой. Үүнээс бид нар 5-ыг нь хэрэгжүүлчихсэн, баталчихсан байж байгаа. Үүний дараа бид нар бүрэлдэхүүн хэсэг 3 зорилго болох дижитал ур чадварыг нэмэгдүүлэх хэмжээний сургалт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байх ёстой. Үүнээс бид нийт 10 мянган иргэдийг сургасан байх ёстой гэсэн зорилт байсан. Харамсалтай нь энэ төслүүдийг хэрэгжүүлэх нь зөвлөх үйлчилгээний гэрээ учраас Сангийн яамнаас энийг санхүүжүүлэх боломжгүй гээд бид нар энэ төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжгүй болоод, төслийг нь дахин бүтэцлэх дараагийн гэрээнд тусгахаар Дэлхийн Банктай хэлэлцээд, Сангийн яамтай хэлэлцээд Засгийн газрын хүрээнд шийдвэрлээд ингээд явж байгаа.../минут дуусав/

**Р.Батболд:** Дахиад гүйцээж хариулъя. Индрийн микрофон дээр өгчих.

**Б.Энхдөлгөөн:** Тэгэхдээ нийт 10 мянгад бид нар ерөөсөө хүрээгүй. Юу ч хийгээгүй гэсэн үг биш. Төслийн хүрээнд яг энэ зөвлөх үйлчилгээг санхүүжүүлэхгүй гэдэг шийдвэр, тогтоол гарахаас өмнө бол бид туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлээд, 1200 ахмад настныг дижитал ур чадварыг сургах хөтөлбөрийг хэрэгжүүлээд дууссан ийм явцтай байсан. Энэ туршилтын хөтөлбөрийг бид улс даяар хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байсан боловч санхүүжилтийн асуудлаас болоод энэ ажлыг зогсоосон.

**Р.Батболд:** Дахиад асуулт байгаа юу. Байхгүй юу. Соронзонболд гишүүнээс томилолттой явж байгаа. Асуугаад өгөөч гэсэн асуултууд байгаад байна. Тэгээд энэ дээр танайтай холбоотой зүйлүүдийг нь асуучихъя. Энэ дата давхардал ер нь хэр байдаг юм бэ. Төр хувийн сектор дээр гэсэн асуулт байна.

Цахим системд ТЭЗҮ боловсруулах ажлын өртөг тооцох, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянаж хүлээж авахад баримтлах шалгуур, зарчим, өртгийг тодорхойлох жишиг үнэ тогтоохтой холбоотой зохицуулалт нь хангалтгүй байгаа шүү гэсэн байна. Энэ дээр бас хариулт өгөх хэрэгтэй юм байна. Бусдыг нь ер нь бичгээр өгчихье. Энэ маш олон асуулт байна. Тэгэхээр энэ 2 дээр ямар ч байсан хариулт аваадахъя.

Би бас нэг юм асуугаадахъя өөрөө. Энэ дижитал ажлын байр гэж яг юу вэ. Индрийн микрофоныг өгчихье.

**Д.Цэнгүүнжав:** 1 дүгээрт нь өгөгдлийн давхардлын асуудал бол байгаа. Ер нь төрийн байгууллагууд тус тусдаа мэдээллийн сан үүсгээд явж байгаа. Хуулиар бол суурь 2 мэдээллийн сан байна. Улсын бүртгэл, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар дээр. Төрөлжсөн мэдээллийн сан бол 152 байна гэж байгаа. Тэгээд бид нарын авсан судалгаагаар жишээлбэл 152 мэдээллийн сангаас 27 байгууллагын 42

мэдээллийн сан үүснэ гэдэг юм уу, иймэрхүү мэдээллүүд байгаа. Тэгэхээр давхардсан мэдээллүүд байгаа. Энийг бас цэгцлэх ажлууд ер нь явж байгаа. ҮСХ, Цахим яам дээр тусдаа ажлын хэсгүүд гараад, салбар дээр гараад энэ дээр бас хамтраад ажиллаад явж байгаа.

2 дахь асуудал дээр Үндэсний аудитын газраас Сангийн яам, Цахим яам дээр зөвлөмж өгсөн. 1 дүгээрт нь цахим систем боловсруулах ажлын өртгийг тооцоход баримтлах жишиг үнийг тогтоох аргачлал боловсруулах, аргачлал байхгүйгээс болоод харилцан ялгаатай янз бүрийн өндөр дүнтэй, бага дүнтэй ийм төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байна гэдэг ийм зөвлөмж өгсөн.

Нөгөө 2 дахь дээр нь бол төрийн байгууллагад ашиглах компьютер, техник хэрэгслийн үзүүлэлт, норм стандартыг салбарын онцлогтой уялдуулан боловсруулах, тэгэхгүй бол төрийн байгууллагууд маш өндөр үзүүлэлттэй, үнэтэй ийм тоног төхөөрөмж аваад байна гэж явж байгаа. Үүний хүрээнд Цахим яамнаас энэ жилийн худалдан авах ажиллагаанд энийг боловсруулах тендерийг зарлаад, эхний ажил бол тайлангаа хүлээлгээд өгсөн. Энийг бид нар холбогдох газруудаас санал аваад, батлах арга хэмжээг авахаар Сангийн яамтай хамтраад ажиллаж байгаа.

2 дахь ажил дээр бас мөн тайланг ирүүлж байгаа. Тэгэхээр тэрний дагуу бид нар хянаж, холбогдох газруудаас санал аваад, эдгээр жишиг баримт бичгүүдийг боловсруулснаар, ийм жишигтэй болсноор энэ асуудлууд шийдэгдэнэ гэж харж байгаа.

3 дугаарт нь системийн дүгнэлт, зөвлөмжийн асуудлууд байдаг. Энэ дээр хуулийн дагуу цахим яамнаас зөвлөмж авах ёстой байдаг. Хэрэгжилт хангалтгүй гэдэг асуудал яригддаг байсан. Сүүлийн үед яамны зүгээс бас Засгийн газар албан даалгавар гаргуулсан. Тэрний хүрээнд төрийн худалдан авах ажиллагааны систем дээр яамнаас дүгнэлт, зөвлөмж аваагүй бол зарлахгүй гэдэг ийм шаардлага тавьж байгаа учраас сүүлийн үед байгууллагуудаас энэ дүгнэлт, зөвлөмж авахаар хүсэлт юмнууд ирдэг болсон байгаа.

**Р.Батболд:** Юуны талаар дижитал ажлын байр гэж яг юу вэ.

**Д.Цэнгүүнжав:** Дижитал экономи буюу дижитал ажлын байр гэдэг бол цахимаар орлого олж, ажлын байртай бий болох энэ асуудлыг ерөнхийд нь ойлгоно. Тэгэхдээ манай энэ төслийн сая хэлсэн одоо зарлагдаад нээгдэхээр байгаа яг энэ 3 дахь нь бол дижитал эдийн засгийг дэмжих буюу дижитал ажлын байрыг бий болгох гэдэг ажил байсан. Зөвлөх үйлчилгээний ажлууд гэдэг утгаараа бүгд хасагдаад, энэ зорилт бүр тэр чигтээ хасагдах ийм аюултай асуудал байна. Тийм учраас 1 ажлыг үлдээгээд саяын хэлсэн 1500 хүнийг сургаад, 1000 хүнийг нь, түүний 50 хувь нь эмэгтэй хүн байхаар ийм шалгууртай ажлын байрны сургалт хийгээд, энэ нь яах вэ гэхээр жишээ нь олон улсын нөгөө цахимаар хийх боломжтой ажлуудын жагсаалт байдаг. Үнэ өртөгтэй. Жишээлбэл тэр дээр ажиллаад, Монголд сууж байгаад компьютер ашиглаад ингээд ур чадвартай хүн тэн дээр бүртгүүлээд, тэр ажлыг хийгээд, тэрнийхээ хөлсийг виз карт гэдэг юм уу түүгээрээ хүлээж аваад, 6 сарын хугацаанд тогтмол ажлын байртай болоод, ядаж доор хаяж 480 доллар олсон байх шаардлагатай ийм ажил байгаа гэсэн үг. Тэгэхээр мянган хүн 6 сарын хугацаанд 1 нь 480 долларыг олсон байж байж энэ ажлыг хүлээж авахаар ийм шалгууртай тендер гэсэн үг. Тэр үлдсэн байгаа ганц дижитал ажлын байрыг нэмэгдүүлэх гэдэг ажил.

**Р.Батболд:** Яах вэ би зүгээр 1500 хүнээр нь бодохоор 1 хүнд ийм байдлаар мөнгө олж болох юм шүү гэдгийг 4 сая 700 мянган төгрөг зарцуулаад зааж өгөх гэж байгаа юм байна. Тийм үү. 1 хүнд 4 сая 700 мянган төгрөг зарцуулж байгаад яг ингээд энүүгээр ороод мөнгө олж болох юм шүү гэж зааж өгөх гээд байгаа юм байна шүү дээ. Тийм тендер юм байна тийм ээ. Мөн үү. Биечилж заахгүй байх. Мэдээж танхимаар юм уу, эсвэл 1, 1-ээр нь аваачиж заах юм уу 1500 хүнийг. 1500 багш байгаа гэсэн үг үү. Цаана нь зааж өгөх. Хариултыг нь индрийн микрофоноор авчихъя. Наадхаа 1 гоё тайлбарлаадах.

**Д.Цэнгүүнжав:** 1 дүгээрт дэлхий энэ ажлынх нь даалгавар нь бол Дэлхийн банкнаас ирсэн буюу ингээд хамтраад, хянаад, зарлаж байгаа. Энэ дээр яг ингэж заана гэсэн юу байхгүй. Энэ дээр аль болох олон улсын яг ийм ижил төстэй арга хэмжээ хэрэгжүүлж байсан, энэ нь өөрөө дэлхийд байдаг юу гэдэг юм хүн сургаад жишээлбэл Косовод би тоог нь андуурч байгаа байх. Жишээлбэл, 300 хүн дээр яг ингэж сургаад, ажлын байр бий болгосон ийм компани байна. Тэгэхээр энэ компаниудтай Монголын компани байвал холбогдоорой гэдэг байдлаар та бүхэн энийг хүргээд, энэ ажлыг явуулах талаас нь анхаараач гэдэг байдлаар жишээлбэл өгсөн гэсэн үг. Тэгэхээр ийм ажлууд хийгддэг. Тэгэхээр Монголд 1500 хүн сургана. мянган хүнд яг хэдээр бүлэглэж, яах нь бол тэр хүмүүс тендерт оролцохдоо бид нар ийм туршлагатай, ингэж хийдэг, ингэж ингэж хийнэ, үр дүн бол 1500 хүн сурна. Мянган хүн ажлын байртай болно. Тэрний 500 нь эмэгтэй байна. Тэгэхээр 1 хүн бол 6 сарын ..../минут дуусав/

**Р.Батболд:** Гүйцээгээд хариулчихъя.

**Д.Цэнгүүнжав:** Тэгээд 1 хүн нь 6 сарын хугацаанд 480 долларыг гадаадын зах зээл дээрээс цахим ур чадвараа ашиглаад, ажил хийгээд, орлого олсон байнагэдэг шалгууртай.

**Р.Батболд:** Байж байгаарай. Одоо 500 хүн чинь яг 480 доллароо олоогүй байвал хариуцлага нь юу байх юм. Тэр шалгуур нь энэ дээр байгаа юу. Хариуцлага нь юу байх юм. 6 сарын дараа тэр 500 хүн чинь 480 доллароо олохгүй байвал яах юм. Бүр мянгаа больё, 1500 ч больё. Ядаж 500 эмэгтэй хүн чинь 480 доллароо олохгүй байвал яах юм бэ. Үүний хариуцлагыг хэн хүлээх юм бэ. Энэ 7 тэрбум төгрөг байна шүү дээ. Тэгээд зүгээр хичээл заах чинь. Энийг хариулаад өгчих.

**Д.Цэнгүүнжав:** Энэ бол гэрээгээр төслийн хэрэгжүүлэлт, энэ төсөл маань хуваарьтай байгаа. Эхний ээлжид 2, 3 ч байна уу. Мянга мянган хүн сургана. Дараа нь 500 ч гэдэг юм уу гэх мэтчилнээр яг тэр гүйцэтгэлээрээ нөгөө мөнгө нь шилжээд явах учраас энэ хэрэгжсэний дагуу мөнгө нь шилжээд орно.

**Р.Батболд:** Үгүй ээ, би заахыг нь яриагүй шүү дээ. Та нар үр дүн яриад байна шүү дээ. 1000 хүн сурна, 1500 хүн сурна. Мянга дотроосоо ядаж 500 хүн нь эмэгтэй байна. 500 ажлын байр бий болчихно гээд байна. Үр дүн нь өөрөө сардаа 480 доллар ядаж олдог ажлын байрнууд юм гээд яриад байна шүү дээ. Тэрийг бий болгохын тулд ийм их мөнгө зараад байна гээд. Хүрэхгүй яах юм бэ гэдэг юм байгаа юм уу, хариуцлага гэж юм байгаа юм уу л гэж асуугаад байхгүй юу. Түүнээс 1500 хүнд би ч гэсэн очоод юу гэдэг юм 1 сайт зааж өгөөд, энүүгээр ингээд байвал бид нар мөнгө олчихдог юм шүү гээд яриад байж болох байх. Зүгээр үр дүн чинь яаж гарах юм. Үр дүн дээр нь хариуцлага яаж тооцох юм. 7 тэрбум төгрөг зарцуулчихаад 1500 хүнд хичээл заасан гэж хэлчихээд, тэгээд хаячихаад явчихвал яах юм бэ л гээд асуугаад байна шүү дээ. Индрийн микрофон өгчихье.

**Д.Цэнгүүнжав:** Гэрээн дээр сургасан, яг ингээд баталгаажсан байдлаар нь санхүүжилт нь олгогдоно гэсэн үг.

**Р.Батболд:** Биш ээ, баталгаажихыг нь асуугаагүй байна шүү дээ. Би мянган хүн бүртгээд эд нарт заагаад өгчихсөн шүү гээд бүртгээд өгчхөж болно шүү дээ. Тэрийг та нар баталгаажсан гэж үзэх юм уу. Эсвэл орлого олж байгаагаар нь баталгаажлаа гэж үзэх юм уу. Яаж тооцох гээд байгаа юм бэ гээд асуугаад байна шүү дээ. Үр дүн нь яг юу юм. Зүгээр 1500 хүний бүртгэл аваачиж өгчхөөд бид нар ингээд сайтаар мөнгө олохыг заагаад өгчихсөн байхгүй юу. Тэгээд 480-ыг олох ёстой байсан чинь эд нар чадахгүй байгаа байхгүй юу гээд ингээд сууж байх юм уу. Яах юм бэ л гээд асуугаад байна шүү дээ.

**Д.Цэнгүүнжав:** Энэ дээр нэмэлтээр зохицуулагч мэдээлэл өгнө. Тэгэхдээ орлогоор баталгаажна. Орлогоор баталгаажна гэдэг шалгуур үзүүлэлт байгаа.

**Р.Батболд:** Харин тийм. Одоо тэрийгээ л сайн хэлээд өгчих. Индрийн микрофоныг өгчихье.

**Б.Энхдөлгөөн:** Online gig job гэдэг ажил бол манай төслийн хүрээнд хэрэгжих хамгийн эцсийн зөвлөх үйлчилгээний гэрээ болж байгаа. Сангийн яамнаас олгож байгаа. Энэ гэрээ маань яагаад заавал хэрэгжих шаардлагатай вэ гэвэл төслийн зээлийн хэлэлцээрт тусгачихсан. Төслийн хөгжлийн зорилгот 1500 хүнийг сургаад, мянган хүний ажлын байрыг бий болгоно гээд заагаад өгчихсөн. Энэ ажлын даалгаврыг бид боловсруулах гэж 2 жил болсон. Яамнаас зөвлөх авч ажиллуулаад, эцэс төгсгөлдөө юу болсон бэ гэвэл төслийн нэгж маань Дэлхийн банктай хамтраад энэ ажлын байрны тодорхойлолтыг, энэ дэд төслийн тодорхойлолтыг боловсруулсан. Боловсруулахдаа юуг тооцсон бэ гэвэл 1 дүгээрт тухайн компани манай тендерт ороод ялсан бол эхлээд яаж энэ 1500 хүнийг сургах вэ гээд Curriculum бэлдэнэ гэсэн үг. Сургалтын хуваарь. Уг сургалтын хуваарийн дагуу сургалтуудаа 2-3 сарын хугацаанд ороод, гадаа саадын олон улсын платформуудыг судална гэсэн үг. Платформууд бид нар бас судалгаа .../минут дуусав/

**Р.Батболд:** Гүйцээгээд хариулъя.

**Б.Энхдөлгөөн:** Олон улсын Fiverr, Upwork гэх мэтчилэн платформууд байдаг. Үүн дээр хувь хүн бүртгүүлээд, ажил хийгээд орлого олох боломжтой. Уг хүмүүсийг хэрхэн сургасан бэ гэдэг нь бол чадамж нь тухайн хүний олсон орлогоор батлагдана. Тэгэхээр тэр сургалт авсан, сургалтад хамрагдсан хүн маань орлого олж чадвал энэ төсөл амжилттай хэрэгжсэн. Мянган хүн орлого олж чадвал амжилттай хэрэгжсэн гэж тооцно. Бид нар тэр орлогыг яаж тооцох вэ гэвэл тухайн мянган хүний Uptown бай, Fiverr, ч бай тухайн платформуос гүйлгээ хийгдсэн дүнгээр нь тооцож, энэ хүн цалингаа үнэхээр авсан байна гээд тухайн аж ахуйн нэгжид бид нар төлбөрийг нь шилжүүлнэ гэсэн үг.

Тэгэхээр бид нар шууд сая хэлсэн 2 сая ам.долларыг тухайн байгууллага руу шилжүүлдэг биш, нийт сургаад цалин олсон хүний тоогоор нь бид ажлынх нь хүрээнд төлбөрийг нь шилжүүлнэ гэсэн үг. Ийм ажил явж байгаа.

Тэгээд нэмэлтээр хэлэхэд уг төсөл маань .../минут дуусав/

**Р.Батболд:** Нэмээд хариулъя.

**Б.Энхдөлгөөн:** Нэмэлтээр хэлэхэд энэ төсөл манай дижитал эдийн засгийн салбарт хэрэгжиж байгаа анхны ийм төсөл. Тэр утгаараа бид олон улсын туршлагатай байгууллагуудаар энийг хэрэгжүүлээд, цаашлуулаад Ай Ти Парк энэ төсөл хөтөлбөрийг Монголдоо суурьшуулаад үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн. Яагаад шууд Ай Ти Паркт энэ ажлыг өгөөгүй вэ гэвэл манай төсөл маань өөрөө худалдан авах ажиллагаа олон улс дээр хэрэгждэг. Төсөл хөтөлбөрийн маань чанар болон зорилгыг олон улсын туршлагатай компаниуд хийж гүйцэтгэдэг гэсэн үүднээс энэ туршилтын хөтөлбөрийг хийгээд, цаашдаа Ай Ти Парк үүнээс нь сураад, Монгол улс даяараа хэрэгжүүлэх боломжтой болно гэсэн үг.

**Р.Батболд:** Ер нь яах вэ би гадаад зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд дээр нэг иймэрхүү дундуур нь зөвлөх үйлчилгээ ч байдаг юм уу, юу ч байдаг юм орж ирээд, мөнгө зүгээр урсаад байдаг зүйл байгаад байдаг. Зүгээр тэр дээр мэдээж бид нар маш их шүүмжлэлтэй хандаад байгаа. Энэ төслийн хувьд зүгээр асууж байгаа юм шүү. Тэгэхдээ үнэхээр ядаж мянган хүн 480 доллар олдог болчих юм бол бид нар сардаа 480 мянган доллар Монгол Улсад орж ирээд байна гэсэн үг шүү дээ. Иргэдийн гар дээр ирнэ гэсэн үг. 4 сарын дотор гэхэд бид нар энэ мөнгөө буцаагаад ядаж иргэддээ зарсан байна гэсэн ойлголтоор явж байгаа гэсэн үг. Хэрвээ үнэхээр тийм байвал сайн байна. Зүгээр гүйцэтгэлээ яаж тооцоод, энэ мөнгөө яаж олгох юм бэ гэдэг дээрээ анхаарч ажиллаарай л гэж хэлэх гээд байгаа юм. Түүнээс биш зүгээр 1500 хүний бүртгэл авчирч өгчхөөд, бид нар ингээд заагаад өгсөн. Тэгээд энэ хүмүүс чинь өөрсдөө ажиллахгүй юм байна ч гэдэг юм уу, юу гэдэг юм тиймэрхүү байдлаар хандаад, мөнгө нь гараад явчихдаг ийм асуудал байвал бас бид нар дэмий мөнгө үрэх гээд байгаа юм л гэж хэлэх гэж байгаа юм. Энэ хэрэгтэй ажил байна. Сайн байна.

Одоо Анар дарга нь орж ирээд асуултуудаа бэлдээд уул нь тавьчихсан байна. 5 минут хүлээж байх уу хэдүүлээ.

Нөгөө дата өгөгдлийн давхардлын талаар бас давхардал арилгах талаар мэдээлэл өгөөч. Тэгээд индрийн микрофоныг нээчихье.

**Д.Цэнгүүнжав:** Цахим яамны зүгээс ҮСХ-той хамтраад энэ чиглэлээр бас уулзалт, арга хэмжээнүүдийг ярилцаад явж байгаа.

1 дүгээрт нь яг энэ стандартын буюу мэдээллийн сангуудаа яг нэгдсэн 1 стандартын дагуу үүсэхгүйгээс болоод мэдээлэл солилцож болохгүй, нэгтгэж болохгүй, боловсруулалт хийж болохгүй асуудлууд байна гэдэг үүднээс Цахим яамнаас стандартыг боловсруулахаар зарлаад, тэгээд энэ дээр бас явж байгаа. Боловсруулаад төсөл гарсны дараа Статистикийн хороотой хамтраад энийг хянаж сайжруулаад батлаад, төрийн байгууллагуудад хэрэгжүүлнэ.

Яг бас энэ өгөгдлийг нэгтгэх буюу их өгөгдлийн сан үүсгэх гэдэг бол Засгийн газрын 2023 оны 403 дугаар тогтоол байдаг. Гэсэн боловч хэрэгжилт бас хангалтгүй. ҮСХ, Цахим яам И-Монгол академитай хамтраад 2, 3 байгууллага дээр туршилт хийсэн. Танигдахгүй болгоод нэгтгээд ийм ажлыг хийчихсэн. Үүний хүрээнд үргэлжлүүлээд ухаалаг засаг төсөл дээр 1 том төсөл явж байгаа. Их өгөгдлийн сан үүсгэх, тэдний системийн тоног төхөөрөмж гээд.

**Р.Батболд:** Цахим хөгжлийн яам нийт улсын хэмжээнд хийгдэж байгаа программ хангамжийн асуудлууд байна шүү дээ. Бүх яаман дээр тус тусдаа яваад байгаа байх. Тэгэхээр энийг нэгтгэж харж байна уу. Жилдээ хэдий хэмжээний тоног

төхөөрөмж яг шаардлагатай, тэрийг төлөвлөлт дээрээс нь харж нийлүүлээд бид нар ер нь яг цахим хөгжилд гэдэг юм уу, цахимдаа ер нь хэдэн төгрөг төсөвлөөд байна гэдгийг та нар ер нь нийлүүлж хардаг уу. Тийм тооцоо байна уу. Индрийн микрофоныг өгчихье.

**Д.Цэнгүүнжав:** Өнөөдрийн энэ 2 дахь хэлэлцэх асуудал төсөл хөтөлбөрийн мэдээлэл гээд танилцуулга байгаа. Тэр дээр яг энэ асуудал уг нь дүнгээрээ юмнууд гарах юм. Бас нөгөө яг хорооноос 2 асуудлаар мэдээлэл авсан.

1 дүгээрт нь Ухаалаг засаг, 2 дугаарт нь төсөл хөтөлбөрүүдийн мэдээлэл гээд.

**Р.Батболд:** Индрийн микрофоныг өгье. Хариулт авъя.

**Б.Энхдөлгөөн:** Түрүүн Жаргалан гишүүний асуулт байсан. Яг тоног төхөөрөмж, мэдээллийн систем нийт хэдэн сая ам.долларын төсөвтэй байгаад байгаа юм бэ гээд. Манай төсөл бол зээлийн хэлэлцээр дээр 40,7 сая ам.долларын төсөвтэй. Үүнээс тоног төхөөрөмж, мэдээллийн систем бол нийт 34,5 сая ам.доллар болж өссөн. Түрүүний нөгөө дахин бүтэцлэлтэй холбоотойгоор. Үүнээс яг тоног төхөөрөмж нь 27,8 сая ам.долларын төсөв бүхий тоног төхөөрөмжийг бид нар одоогоор төлөвлөөд явж байна. Мэдээллийн систем нь 6,7 сая ам.доллар бүхий 11 мэдээллийн систем байна. Ингээд хувь зөвлөхүүдийн 22 хувь зөвлөх байсан. Үүнээс ихэнхийнх нь гэрээ нь дууссан болон цуцлагдсан. Энэ нь 918 мянган доллар төсөвлөгдөөд, заримынх нь төлбөр нь орчихсон. Зөвлөхийн бус буюу түрүүн ярьсанчлан бүрэлдэхүүн хэсэг 3-ын Online gig job гэдэг ажил маань 2 сая ам.долларын төсөвтэй. Ингээд нийт.../минут дуусав/

**Р.Батболд:** Гүйцээгээд хариулчихъя.

**Б.Энхдөлгөөн:** Ийм байдлаар төсөв маань хуваарилагдсан байна. Тэгэхээр үүнээс харахад ерөөсөө зөвлөхийн үйл ажиллагаа байхгүй. Зөвлөх үйлчилгээ байхгүй. Төслийн ихэнх нь тоног төхөөрөмж болон мэдээллийн систем байна.

**Ч.Анар:** Цэнгүүн гишүүн тодруулах уу. Асуулт давхардсан байж магадгүй. Яагаад гэхээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр илтгэл танилцуулаад.

Энэ “Ухаалаг засаг 1” дүгээр хөтөлбөрийн хүрээнд аудит хийж, дүгнэлт танилцуулсан юм уу. Одоо энэ ашиглаж байгаа системүүд нь хэд байгаа вэ. Манай улс чинь зарлахаар бол цахимжуулалтыг маш амжилттай хийсэн гээд байдаг. Дахиад 41,7 сая долларын санхүүжилтээр хөтөлбөр хэрэгжиж байна. Тэгэхээр “Ухаалаг засаг 1” дээр ямар ямар төсөл хөтөлбөрүүд хэрэгжээд, бид нар өнөөдөр ард иргэд болон бид хэрэглээндээ нэвтрүүлсэн байгаа юм бэ гэдэг 1 дүгээр асуулт.

2 дугаарт таны тайлан дээр 1 тоо зөрөөд байна. Энэ 2026 оны 4 дүгээр сарын байдлаар нийт хугацааны 68 хувьд хүрсэн байхад чанарын гүйцэтгэлд 36,3 хувь, төсвийн ашиглалт 25,2 хувь, нийт зээлийн зарцуулалт 16,2 хувь байгаа гэж танилцуулсан боловч түрүүн та энэ дэд хороон дээр танилцуулахдаа 75 хувьтай гэсэн. Тэгэхээр энэ 2 тоо 1 сарын дотор ийм хурдан гүйцэтгэл хийсэн юм уу. 2 дугаар асуудал.

Зөвлөх үйлчилгээний талаар гишүүд маань асуучихсан юм шиг байна.

3 дугаарт нь ер нь яг ямар бодит үр дүнд хүрэх вэ. Одоо энэ цахим шилжилт хийхэд шаардлагатай байгаа дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах ажлыг Ай Ти Инсайт гэж компани хийж боловсруулсан байна. Тэгэхээр миний харж байгаагаар цахим яамны хамгийн том асуудал бол төрийн байгууллагуудын цахимжилт нь бүгдээрээ тусдаа. Дүрэм, журам нь нийцэхгүй. Засгийн газрын бүтцийн байгууллагууд. Энэ 2024 онд Их Хурлын даргын 137 дугаар тогтоолоор төрийн процессын дахин инженерчлэл гээд ажлын хэсэг гарсан. Тэр ажлын хэсгийн хүрээнд би ажиллахад бүх яамд нь бүгдээрээ цахим худалдан авалт, бүгдээрээ адилхан систем хийдэг. Тэгээд энэ системүүд нь хоорондоо уялддаггүй, мэдээллүүдээ хуваалцдаггүй, танай яамнаас зөвлөмжөө авдаггүй. Хуульд заасан чиг үүргийнхээ дагуу авдаггүй. Тэгээд ингээд яамыг хүчгүйдүүлсэн. Тэгэхээр энэ судалгааг энэ Ай Ти инсайт гэж компаниараа хийлгэсэн юм байна гэж ойлгож байна. Зөв үү. Тэгэхээр энэ дээрээ гол төрийн байгууллагуудын хоорондын хууль, дүрэм журмын судалгаагаа цэгцлэхгүй бол тал талд бас эргээд танай яам чинь өөрөө энэ том төсөл хэрэгжүүлээд байгаа юм биш үү.

Миний хамгийн их харж санаа зовж байгаа зүйл юу юм бэ гэхээрээ мэдээллийн технологийн худалдан авалтыг ерөөсөө ард иргэд болон Улсын Их Хурлын гишүүд, Үндэсний аудитын газрууд үнэлэлт, дүгнэлт өгч мэддэггүй. Маш сүртэй сүртэй гоё нэртэй. Энэ нэрснүүдийн ард төрийн институцүүдийн маш олон тендер зохион байгуулагдаж байна. ТӨК-удаа багасгах гээд байж байтал төрийн өмчид аппликэйшнүүд зөндөө гараад ирчихсэн. Тэгээд энэ чиглэлээрээ энэ ухаалаг засаг 1, 2 чинь энэ бүгдийгээ базаж чадаж байгаа юм уу, чадахгүй байгаа юм уу. Энэ 3 асуултад хариулт авъя. Цэнгүүнжав дарга. Индрийн микрофон.

**Д.Цэнгүүнжав:** 1 дүгээрт нь “Ухаалаг засаг 1” төсөл бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр байсан. Сүүлд цахим яаман дээр “Ухаалаг засаг 2” ирсэн буюу “Ухаалаг засаг 1”-ийн мэдээлэл Хэрэг эрхлэх газар дээр байгаа. Тэгэхдээ яах вэ бид нар нөгөө манай салбарт хэрэгжсэний хувьд мэдэж байгаа. Жишээлбэл, Дарханы дата төвийн нөөц, Үндэсний дата төвийн нөөц төв гэдэг арга хэмжээ бол яг манай харьяа дата төв дээр хэрэгжсэн том төсөл байгаа. Мөн тоног төхөөрөмжийг сайжруулах ийм төслүүд байгаа. Таны асуусан нөгөө “Ухаалаг засаг 1” дүгээр асуудал дээр байсан. 2 дээр нөгөө төсөл хөтөлбөрийн танилцуулга гээд асуудал байгаа. Тэр дээр танилцуулга яваагүй байгаа. Тэр дээр дүгнэлт, зөвлөмжийн бас мэдээллүүд байгаа. Тэр дээр хамт хариулбал болох уу. Танилцуулга дээрээ.

3 дахь нь уялдаа тэр дээр бас яригдана. Одоо энэ хэлэлцэж байгаа асуудал 1-тэйгээ холбогдолтой та энэ дээр давхар тайлбарлаад явах хэрэгтэй. Индрийн микрофон.

**Д.Цэнгүүнжав:** Ер нь яг энэ асуудал яригдсан. Хуулиар бол цахим яамнаас дүгнэлт зөвлөмж ав. Ингэж байж тэр давхардал, давхардсан зардал, давхардаж байгаа системүүдийг ялгааг нь ингэж давхардуулахгүй байх боломжтой гэж хуулиар зохицуулчихсан. Хэрэгжилт хангалтгүй байна гэдэг асуудлууд яригдаж, дэд хорооноос хүртэл Засгийн газарт асуулгууд яригдаж байсан. Өнгөрсөн 2025 оны 11 сард Хяналт хэрэгжүүлэх газар Цахим яам хамтраад цахимжсан гэсэн мөртөө цаасаар жишээлбэл цахимжилт амжилтгүй, асуудал байгаад байгаа юм биш үү. Яагаад гэхээр цахимжсан гэсэн мөртөө маш их гомдол ирж байна гээд 11 11 өргөдөл гомдол дээр сууриалаад бид нар шалгалтыг хийсэн. Эрүүл мэндийн яам, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэл гэх мэтчилнээр. Үүгээр яваад ямар асуудал гарсан бэ гэхээр ерөөсөө хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Тэгээд 2026 оны 2 сард 02 дугаартай албан даалгавар гаргуулсан. Үүний хүрээнд сүүлийн үед энэ дүгнэлт,

зөвлөмжийн асуудал маш сайн явж байгаа. Албан даалгавар дээр дүгнэлт, зөвлөмж аваагүй бол худалдан авах ажиллагааны системээр зарлахгүй байх гэдэг.../минут дуусав/

**Ч.Анар:** Нэг тодруулга хийе. Энэ Их Хурлын тогтоолууд хэрэгжихгүй, хуулиуд хэрэгжихгүй, тогтоол хэрэгжихгүй асуудал байна. Та бүхний танилцуулгууд дээр Их Хурлын 81 дүгээр тогтоол дээр зөвлөх үйлчилгээ авахгүй гэсэн мөртөө та нарын энэ худалдан авалт дээр аягүй олон зөвлөх үйлчилгээний гэрээнүүд хийсэн байна. Гишүүд асуусан байх. Тэгэхдээ дахиад би тэрийг тодруулж тайлбар сонсьё. Индрийн микрофон.

**Д.Цэнгүүнжав:** Яг таны хэлсэнчлэн зөвлөх үйлчилгээнүүд 3 багц байсан. Хууль, эрх зүйн болон эхний хэсэг ерөнхийдөө тэр чигээрээ зөвлөх үйлчилгээний ажлууд байсан. Тэгэхээр анх 69 байсныг нь хуулийн тэр тогтоолын дагуу Сангийн яамнаас бүх зөвлөх үйлчилгээг хасаг чиглэл өгөөд, ер нь одоо бол зөвлөх үйлчилгээ ер нь байхгүй. Тэр 3 дугаар багц буюу дижитал эдийн засгийг нэмэгдүүлэх гэдэг дээр тэр чигээрээ нөгөө зорилт маань өөрөө тэр чигээрээ байхгүй болох гэж байгаа учраас 1 зөвлөх үйлчилгээг үлдээе гэдэг байдлаар Дэлхийн банк Сангийн яамтай ярилцаад үлдээсэн буюу иймэрхүү байдлаар явж байгаа. Ганц нэг шаардлагатай зөвлөх үйлчилгээ үнэхээр техникийн даалгавар боловсруулах ч гэдэг юм уу, хяналт тавих иймэрхүү ажлууд бол зөвшилцсөний дагуу явж байгаа. Ер нь бүх зөвлөх үйлчилгээний төслүүд бүгд хасагдсан. 81 дүгээр тогтоолын дагуу.

**Ч.Анар:** Тэгэхээр Их Хурлын ашиглахгүй гэсэн тогтоолыг та хэд хоорондоо зөвшилцөөд ашиглаад байгаа гэж ойлгож болох уу. Та тэгэхээр зарим нэгэн зөвлөх үйлчилгээ төсөл зогсох гэж байгаатай холбогдолтойгоороо зөвшилцөөд гээд Дэлхийн банктай зөвшилцсөн юм уу, Их Хуралтай зөвшилцсөн юм уу. Энэ чинь Их Хурлын 81 дүгээр тогтоол чинь өөрөө хэрэгжих нь зөвлөх үйлчилгээг ашиглахгүй гэсэн тогтоол гарчихсан юм байна шүү дээ. Индрийн микрофон.

**Д.Цэнгүүнжав:** Энэ дээр бол Сангийн яам Дэлхийн банктай яг нөгөө хэлэлцээрийн хүрээнд хэлэлцээрээр энэ зорилт маань өөрөө соёрхон батлагдсан. Тэгэхээр энэ хэлэлцээрийн өөрчлөлтүүд энэ ажил маань бас хэрэгжих ёстой буюу ядаж 1 арга хэмжээ гэдгээр энэ ажлыг үйлдсэн гэж ойлгож байгаа. Энэ дээр нэмэлтээр зохицуулагч мэдээлэл өгнө.

**Ч.Анар:** Нэр, албан тушаалаа хэлээд, индрийн микрофон 3 минут.

**Б.Энхдөлгөөн:** Сайн. Байцаана уу. Б.Энхдөлгөөн Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч. Тэгэхээр та бүхэн сая дурдлаа. 2024 оны 6 сарын 5-ны өдөр Улсын Их Хурлын 81 дүгээр тогтоол батлагдсан. Одоо манай төсөл дээр хэрэгжиж байгаа болон хэрэгжиж дууссан зөвлөх үйлчилгээнүүд яг энэ тогтоол батлагдахаас өмнө буюу төслийн зээлийн хэлэлцээрт тусгасан зөвлөх үйлчилгээнүүд хэрэгжсэн. Үүнээс хойш төслийн хүрээнд хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээнүүдийг бид бүгд хасаад, 2026 оны 2 сарын 26-ны өдөр төслийн дахин бүтэцлэх саналд тусгаад ингээд зөвлөх үйлчилгээ байхгүй болсон байгаа. Сая хэлсэнчлэн бүрэлдэхүүн хэсэг 3-ын ганц үйлчилгээ нь цахим ажлын байр бий болгох гэдэг ажил байгаа. Энэ ажил бол манай худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд зөвлөхийн бус үйлчилгээгээр тусгагдсан байгаа.

Тэгэхээр нийт төсвөөр нь танилцуулбал сая бас Жаргалан гишүүнд хариулт өгч байсан. Дахиад нэмэлтээр танилцуулъя. Манай нийт төслийн 40,7 сая

ам.долларын нийт 34,5 сая ам.доллар нь ерөөсөө тоног төхөөрөмж болон систем, үүний 27 сая ам.доллар нь зөвхөн тоног төхөөрөмж, 6,7 систем байгаа. Энэ дээр нэмэх нь манай зөвлөхийн бус буюу саяын 2 сая ам.доллар. Тэгээд нэмээд манай төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны зардал 2 сая ам.доллар ингээд төсөв маань нийтдээ дүүрч байгаа гэсэн үг. Тэгэхээр нийт зөвлөхийн үйлчилгээ бид 2024 оны 6 сарын 5 хүртэл хэрэгжүүлсэн 757 мянган ам.доллар хэрэгжүүлээд, тайлангууд нь зарим нь дуусаад ингээд хэрэгжээд дуусаж байгаа гэсэн үг.

**Ч.Анар:** Гишүүд асуулт асууж дууслаа. Тэгэхээр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Байхгүй байна. Би үг хэлье.

Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолтой Инновац, цахим бодлогын дэд хорооны зүгээс “Ухаалаг засаг 1, 2” төсөлтэй холбогдолтой асуудлыг танилцаж дууслаа.

Тэгэхээр яамны зүгээс ийм юм зайлшгүй хийх шаардлагатай байна. Энэ улсын төсөв дээр та бүхэн хүссэн, хүсээгүй жил болгон ирэх жилүүдэд мэдээллийн технологи, цахим худалдан авалт, цахим дэд бүтэцтэй холбогдолтой төсвүүд нэмэгдэж орж ирнэ. Бид нарын өдөр тутмын амьдрал улам бүр цахимжиж байгаа үед. Энэ дээр бол цахим яам өөрөө хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх дээр төрийн залгамж халаа болон институцүүдийн хямралд орж байгаа. Хүндрэлтэй байгаа. Эрх зүйн хувьд ч гэсэн хүндрэлтэй байгаа. Тэгэхээр энэ асуудлуудаа төрийн байгууллагууд, бусад төрийн яамдын чиг үүргийн байгууллагуудад мэдээлэл технологийн худалдан авалт, дэд бүтцийн худалдан авалтад хуульд заасан чиг үүргээр хэрэгжүүлэхэд ямар хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа вэ. Эрх зүйн хувьд ямар хүндрэл бэрхшээл тулгарч байгаа вэ. Энэ судалгаанууд хийх ёстой байгаа. Их Хурлаас баталсан тогтоол байгаа. 2026 оны 5 дугаар сард Засгийн газарт танилцуулах ёстой. Тэр танилцуулгыг Төрийн байгуулалтын байнгын хорооноос ажлын хэсгийг ахалж байсан гишүүний хувьд бид нар нэхэж, Төрийн байгуулалтын байнгын хороо дээр сонсоно.

Төрд байгаа иргэний болон онц чухал, эмзэг мэдээллүүдийг дахин дахин иргэдийг хүндрэл учруулж авдаг асуудлыг халах ёстой. Үүнийг технологиор л шийднэ. Үүнийг шийдэх гол зохицуулагч байгууллага нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам. Тэгэхээр та бүхэнд тулгарч байгаа асуудлаа тэр тогтоолын төслийн дагуу Засгийн газарт саналаа маш сайн өгөөд оруулж ирэхгүй бол ямар нэгэн хүндрэл бэрхшээл орж ирэхээр ингээд тайлан тавихаар ийм ч асуудал байна, тийм ч асуудал байна гээд яриад байгаа. Тэгэхдээ бүр сүүлд нь яриад байгаа. Урьдчилаад энэ асуудлуудаа оруулж ирэх шаардлагатай байна. Тэгэхгүй бол одоо ингээд манай дэд хорооны зүгээс санаа зовж байгаа юм бол нэр нь мэдэгдэхгүй гоё гадаад нэр томъёотой төсөл хөтөлбөрүүд том үнийн дүнтэй хэрэгжих эрсдэлүүд их байна. Эргээд энэ нь өөрөө хэзээ нэгэн өдөр бас л Их Хурал дээр сонсгол гэдэг юмнууд явагддаг болох вий дээ гэдэгт санаа зовж байгаагаа. Та бүхэн энэ дээр асуудлыг өнгөрсөн борооны хойноос цув нөмөрч танилцуулах биш, урьдчилаад санал, дүгнэлтүүдээ Засгийн газартаа өгөөд, хууль, эрх зүйн хүрээнд нь эхлээд цэгцлэх хэрэгтэй байна.

2 дугаарт яах вэ, тэр асуудлуудаа нээлттэй танилцуулж, Инновац, цахим бодлогын дэд хорооны дэмжлэгийг авч, хууль болон тогтоолын хэрэгжилтийг хангахад хангахад хамтарч ажиллах шаардлагатай байна гэж үзэж байна. Баярлалаа та бүхэнд.

13.32 цаг.

Дараагийн асуудалдаа оръё.

**Хэлэлцэх асуудал 2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг сонсоно.**

Дэд хорооны гишүүдийг дуудъя.

Хэлэлцэх асуудал Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр санхүүжүүлсэн мэдээллийн технологийн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнгийн талаарх Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны мэдээллийг сонсох байсан. Гэхдээ Төрийн байгуулалтын байнгын хороо болон Эдийн засгийн байнгын хорооны хуралдаан давхцаж байна. Дэд хорооны дарга миний бие бас тухайн Байнгын хороонд илтгэл тавих шаардлагатай, гишүүдийн ирц хүрэлцэхгүй байгаа тул энэ хэлэлцэх асуудал 2-ыг ирэх 7 хоногийн хуралдаан хүртэл хойшлуулсныг мэдэгдье.

Өнөөдрийн дэд хорооны хуралдаан хаасныг мэдэгдье.

Хүрэлцэн ирсэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон бусад албан тушаалтнуудад талархал илэрхийлье. Хуралдаан хаасныг мэдэгдье.

13.36 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ  
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ*

*Э.СУВД-ЭРДЭНЭ*